

**ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, НИЙТЛЭЛ**  
**АЗИ ТИВ ЭНХ АМГАЛАН БАЙХ ЁСТОЙ!**  
**(Находкад болсон уулзалт)**

**Ё. Өнөборгил**

Нутаг дэвсгэрийн 75 хувь нь Азид оршдог ЗСБНХУ-ын хамгийн дорно зүгийн усан боомтыг Находка гэдэг. Номхон далай Япон тэнгэсийн эрэг дагуу байрладаг үзэсгэлэнт сайхан байгальтай Находка хот 1981 оны 9-р сард Азийн социалист орнуудын энх тайвны хороондын төлөөлөгчдийг халуун дотноор хүлээн авлаа.

Энх тайвныг хамгаалах Зөвлөлтийн хорооны санаачлан хийсэн зөвлөлдөх уулзалтад ЭТХЗХ-ны дарга академич Е. К. Федоров, ДЭТЗ-ийн дэд ерөнхийлөгч, ЭТХВХ-ны дарга Ван Ань, ЭТХЛХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга, БНАЛАУ-ын сурталчилгаа, мэдээлэл, соёл жуулчдын Яамны орлогч сайд Сон Хамванвонгса, БНКАУ-ын Эрүүлийг хамгаалах Яамны сайд, ЭТХКХ-ны дарга Ит Ким Сенг, МЭТНБХ-ны Гүйцэтгэх Хорооны дарга Н. Лувсанчүлтэм нар тэргүүтэй дээрх орнуудын энх тайвны хороодын төлөөлөгчид оролцов.

БНСВУ, БНКАУ, БНАЛАУ, БНМАУ, ЗСБНХУ-ын энх тайвны хороодын төлөөлөгчид Ази тивийн тулгамдсан асуудлууд, түүний дотор Алс Дорнод Зүүн өмнөд Азийн бүс нутгийн байдалд дүн шинжилгээ хийж ах дүү орнуудын энх тайвны талынхны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах асуудлаар санал солилцов.

Уулзалт дээр академич Е. К. Федоров, АНУ тэргүүтэй империалист бүлгийнхэн, бээжингийн жанжлах үзэлтэн хийгээд бусад харгис хүчний түрэмгий бодлогын уршгаар дэлхий дахины улс төрийн уур амьсгал 80-аад оны зааг дээр эрс хүндэрлээ. Ийм нөхцөлд цөмийн дайны аюул заналыг сэрэмжлэн зайлуулахын төлөө, зэвсгийг хурааж, намжмал байдлын үйл явцыг үргэлжлүүлэх тэмцэлд дэлхий дахины энхийг эрхэмлэгч хүчин идэвхтэй оролцож байгааг цохон тэмдэглээд түүний тод томруун жишээ болгон Өрнөд Европт болсон энх тайвны марш, манай гаригийн бусад тивд өрнөж буй олон нийтийн хөдөлгөөнийг онцлон дурдлаа.

Ази тивийн социалист орнуудын энх тайвны хороодын төлөөлөгчдийн анхны энэ уулзалтын ач холбогдол нь ах дүү социалист

орны нам, төрийн тууштай энх тайванч гадаад бодлого, тэдгээрээс Ази, Номхон далайн сав нутагт энх тайван, тогтвортой байдал, итгэлцлийг тогтоон бэхжүүлэх талаар дэвшүүлсэн шинэ санаачлагуудыг сурталчлан хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг улам эрчимжүүлж зохицуулахад оршиж байв.

Тус уулзалтад ЗХУКН-ын Приморск хязгаарын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга В. П. Ломакин, мөн хязгаарын намын хорооны нарийн бичгийн дарга В. Д. Сафранов, хязгаарын ЭТХХ-ны дарга А. С. Тихомиров, Находка хотын гүйцэтгэх захиргааны дарга Н.Д. Буханцев, олон нийтийн байгууллагын удирдах ажилтан, хөдөлмөрийн сайчууд оролцов.

В. П. Ломакин энд хэлсэн үгэндээ, Социалист Вьетнамтай биднийг холбосон «найрамдал гүүр» Владивосток, Находкийн эргээс эхэлдэг юм. Манай тэнгэсчид, ачаа зөөгчид БНКАУ-д ах дүү ёсны тусламж үзүүлж байна. Приморск хязгаар БНСАУ-ын Умард Хамген мужтай олон нийтийн болон соёлын харилцаагаа байнга өргөжүүлсээр ирлээ. Тус хязгаарын хөдөлмөрчид Зөвлөлт-лаосын харилцааг өргөжин хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж байна. БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын ах дүүгийн халуун барилдлагаа улам бэхжин хөгжихөд манай хязгаарын хөдөлмөрчин олон багагүй зүйлийг хийж байна гээд Азийн социалист орнуудын энх тайвны хороодын төлөөлөгчдийн энэ уулзалт энх тайвны төлөө тэмцэлд ард түмний эв нэгдлийг бэхжүүлэхэд шинэ түлхэц үзүүлэх нь эргэлзээгүйг тэмдэглэв.

ЭТХЗХ-ны төлөөлөгч, түүхийн ухааны доктор, профессор Г.В.Астафьев тавьсан илтгэлдээ Азийн одоогийн улс төрийн байдалд дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийж, дэлхийн энэ бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг хангахад Азийн социалист орнуудаас дэвшүүлсэн энх тайванч оновчтой саналуудын ач холбогдлыг тодорхойлон заав.

Империалист харгис хүчин эдүгээ өөрийн шинэ хань хамсаатан Бээжингийн жанжлагч үзэлтнүүдийн хамт юуны өмнө Зүүн өмнөд Азид гарсан дэвшилт өөрчлөлтүүдийг нухчин дарахыг санаархаж байна. Бүрэн эрхт социа-

лист Вьетнамын эсрэг 1979 оны хоёрдугаар сард хятадын түрэмгийлэгчдээс бузар дайн өдүүлсэн явдал дэлхийн олон нийтэд

бээжингийнхний жинхэнэ нүүр царайг илчилсэн юм. Тэд Зүүн өмнөд Ази дахь хувьсгалт хөдөлгөөнийг зогсоохын тулд ямар ч харгис хүчинтэй сүлбэлдэхээс буцахгүй болов. Империалист хүчин, жанжлах үзэлтнүүд «Кампучийн асуудал» гэгчийг тойруулан шуугиан дэгдээж, НҮБ болон олон улсын бусад байгууллагуудад энэ асуудлыг шургуулан оруулахыг эрмэлзэж байна.

«Кампучийн асуудал» гэгч огт байхгүй бөгөөд Кампучийн сэргэн мандалт бол эргэлт буцалтгүй зүйл мөн гэж профессор Г. В. Астафьев цохон тэмдэглэв.

Ази тивийн энэ бүс нутагт энх амгалан, аюулгүй байдлыг хангах хэрэгт өнгөрсөн нэгдүгээр сард Хошимин хотноо болсон Вьетнам, Кампучи, Лаосын ГЯЯ-ны сайд нарын ээлжит бага хурлаас дэвшүүлсэн санаачилга асар их ач холбогдолтой юм. Зүүн өмнөд Азийн байдлыг хэвийн болгохын тулд Энэтхэг-хятадын хойг болон АСЕАН-ны орнуудын бүсийн бага хурал хуралдуулах саналыг гурван орны ГЯЯ-ны сайд нар дэвшүүлсэн билээ.

Социалист орнуудын явуулж буй энх тайванч тууштай гадаад бодлогыг дэлхийн, түүний дотор Азийн олон нийтэд тайлбарлан сурталчлах, тэднийг энх тайвны талынхны хөдөлгөөнд идэвхтэй дайчлан оролцуулах явдал бидний нэн тэргүүний зорилт юм гэж Вьетнамын төлөөлөгчдийн тэргүүн нөхөр Фан Ань тэмдэглэв.

Лаосын төлөөлөгчдийн тэргүүн нөхөр Сон Кхамванвонгса ярихдаа:

БНАЛАУ-ын эсрэг империалист бүлгийнхэн, бээжингийн жанжлагч үзэлтнүүд байнга өдөөн хатгалга үйлдэж, тус орныг сонгож авсан социалист хөгжлийн замаас нь хүчээр гаргах, хуучны дэглэмийг сэргээн тогтоохыг улайран оролдож байна. Одоо Лаосын хил дагуу Хятадын цэргийн томоохон ангиудыг байрлуулж, тус улсын аюулгүй байдалд заналхийлсээр байна.

Гадаадад дүрвэж гарсан харгис бүлгийнхэн «чөлөөлөх фронт» гэгчийг эмхлэн байгуулж хөрш зэргэлдээ Тайландын нутаг дээр дээрэмчдийн бүлгийг бэлтгэж байна. Тэдгээрийг зэр зэвсгээр хангах, аллага, хядлагын сургууль хийхэд империалист хүчин, тэдний хань хамсаатнууд хүч, хөрөнгө хайрлахгүй нийлүүлж байна. Мөн эдгээр хүч манай орныг эдийн засгийн талаар боож хавчих бодлого явуулж байна. Тухайлбал Тайланд манай улстай хилээ хааж, худалдааг зогсоов. Хэдийгээр байдал ийм хүнд байгаа боловч Лаосын ард түмэн өөрийн зорьсон зорилгодоо хүрнэ гэдэгт итгэл дүүрэн байна. Учир нь бидний талд аугаа их Зөвлөлт гүрэн, социалист хамтын нөхөрлөлийн бусад орон, дэлхий дахины дэвшилт ард түмэн бат зогсож байна гэв.

Кампучийн төлөөлөгчдийн тэргүүн нөхөр Ит Ким Сенг хэлсэн үгэндээ: Бээжингийнхний дуулгавартай зарц Полпот-Йенг Сарийн цуст дэглэмийг унагаснаас хойш ардын эрхт Кампучид үндэсний сэргэн мандалт хэрхэн явагдаж байгаа болон түүнд ЗХУ, социалист бусад орнуудын оруулж буй их хувь нэмрийн талаар дэлгэрэнгүй яриад, империалистууд хятадын жанжлагчид болон харгис бусад хүчнээс Кампучийн эсрэг үйлдэж буй түрэмгий бодлогыг тодорхой тоо баримттайгаар илчлэв.

Монголын төлөөлөгчдийн тэргүүн нөхөр Н.Лувсанчүлтэм:Америкийн империализм, бээжингийн жанжлагч үзэлтний түрэмгий илт бодлогыг зэмлэн буруушаагаад, социалист хамтын нөхөрлөлийн орнууд дэлхий дахинд энх тайвныг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хазаарлах, дайны аюулыг сэргэмжлэн зайлуулах, аливаа хямралыг хэлэлцээрийн замаар зохицуулахын төлөө цуцалтгүй тууштай тэмцэж байгааг ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлж, дэлхийн олон нийтийн өргөн дэмжлэг талархлыг хүлээж байгаа 80-аад оны энх тайвны программ харуулж байна.

Алс Дорнодод итгэлцэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх Зөвлөлтийн саналыг халуунаар дэмжин Ази тивд энх тайвныг бэхжүүлэх үйлсэд өөрийн нэмэр хандиваа оруулах чин эрмэлзлээр жигүүрлэсэн БНМАУ, МАХН-ын XVIII их хурлаараа Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах саналыг дэвшүүлснийг тэмдэглэж, Зүүн өмнөд Ази болон Дундад, Дорнодод түгшүүртэй байдлыг намжаахад чиглэсэн Вьетнам, Лаос, Кампучи болон Ардчилсан Афганистаны тодорхой саналыг монголын олон нийт шийдвэртэй дэмжиж байгааг илэрхийлэв.

ЭТХМХ-ны төлөөлөгч Б. Дашцэрэн АНУ, НАТО болон бусад милитарист түрэмгий хүчинтэй цэрэг-улс төрийн талаар шууд сүлбэлдэж хамтран ажиллах замд орсон хятадын жанжлах үзэлтнүүд Ази тивийн тусгаар тогтносон улс орнуудын төрийн бүрэн эрхт байдал, газар нутгийн халдашгүй эрх чөлөөнд яаж аюул учруулж байгааг нотлон ярив.

Уулзалтад оролцогчид хэлэлцсэн бүх асуудлаар санал бүрэн нийлж ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн Энх тайвны программ, Зүүн өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдлын бүс болгох тухай БНСВУ, БНКАУ, БНАЛАУ-ын оновчтой санал, Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах БНМАУ-ын цаг үеэ олсон санаачлагатай бүрэн дүүрэн дэмжиж байгааг илэрхийлсэн хамтарсан мэдэгдэл гаргав.

Социалист орнуудын эдгээр энх тайванч  
санаачилга нь

Азийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх таатай нөхцөлийг бүрэлдүүлж, тус тивийн орнуудын олон нийтийн хамгийн өргөн давхрага энх тайвныг сахин хамгаалж бэхжүүлэх тэмцэлд хамтран, ажиллах мөрийн хөтөлбөр болж болох юм. Тийм ч учраас уулзалтад оролцогчид зэвсэглэлээр хөөцөлдөхийн эсрэг империализм, жанжлалын болон харгис хүчний түрэмгий бодлогын эсрэг, дайны аюулын эсрэг тэмцэж байгаа азийн орнуудын улс төрийн янз бүрийн чиг баримжаа бүхий олон нийтийн, тухайлбал үйлдвэрчин, залуучууд эмэгтэйчүүд, шашны зэрэг дэвшилт ардчилсан байгууллагатай хамтран ажиллахад бэлэн байгааг мэдэгдэлд заав.

Ах дүү орны энх тайвны үндэсний хороодын төлөөлөгчид Находка хотноо хэвлэлийн бага хурал хийв.

## **МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТУСГААР ТОГТНОЛЫГ СЭРГЭЭН ТУНХАГЛАСНЫ 70 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ**

Монголын үндэсний тусгаар тогтнолыг сэргээн тунхагласны 70 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал Улаанбаатар хотноо 1981 оны арван нэгдүгээр сарын 25-нд болов.

БНМАУ-ын ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Дорнодахины судлалын хүрээлэнгээс эрхлэн хийлгэсэн тус бага хуралд ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор, профессор С. Д. Дылыков, ЗСБНХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан дэд эрдэмтэн Р. М. Неронов нар оролцов.

Бага хуралд «Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 70 жилийн ой» гэсэн илтгэлийг академич Ш. Нацагдорж тавив. 1911 оны монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн бол манжийн байлдан дагуулагчид ба хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийн эсрэг монголын ард түмний хийсэн урт удаан тэмцлийн шууд үргэлжлэл, түүний эүй ёсны үр дүн байлаа. Энэ хөдөлгөөн 1905 оны Оросын хувьсгалын шууд нөлөөн дор өрнөсөн.

1911 оны монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь манжийн ноёрхлыг бүрмөсөн устгаад зогсоогүй Монгол орныг эзлэн авч, хүчээр нэгтгэх гэсэн хятадын их хан үндэстний түрэмгий бодлогод хүчтэй цохилт болсныг илтгэгч онцлон тэмдэглэв.

Академич Ш. Нацагдорж илтгэлийнхээ төгсгөлд орчин үед маогийнхан хятад төвийн хар-

Уулзалтад оролцогчид Приморск, Хабаровск хязгаарын үйлдвэр, соёлын газраар зочилж, хөдөлмөрийн хамт олон, шинжлэх ухаан, соёлын зүтгэлтнүүдтэй уулзаж, коммунизм байгуулагчдын өрнүүн их ажил үйлстэй танилцав. Эдгээр уулзалт, цуглаан, яриа нь ард түмний найрамдлын сайхан илэрхийлэл болж байв.

Ази тив энх амгалан байх ёстой гэсэн үзэл санааны дор Находка хотноо болсон Азийн социалист орнуудын энх тайвны хороодын төлөөлөгчдийн уулзалт нь энэ тивийн энх тайвны талынхны хөдөлгөөнийг улам эрчим далайцтай болгох арга замыг тодорхойлох, үндэсний байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалтыг цаашид улам нягтруулахад чухал хувь нэмэр бүхий арга хэмжээ боллоо.

гис үзэл бодлогын үүднээс монголын ард түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хийсэн тэмцлийн утга агуулгыг санаатайгаар гуйвуулахыг оролдохдоо энэ хөдөлгөөнийг Хаант Орос улсын тухиралтаар гарсан ард түмний эсрэг чиглэсэн харгис хөдөлгөөн байсан мэтээр харуулахыг оролдож байгааг шуумжлэн тэмдэглэв.

ШУА-ийн сурвалжлагч гишүүн Ц.Пунцагноров «Оросын 1905-1907 оны хувьсгал Монгол орон, Дорно дахинд нөлөөлсөн нь»-гэдэг илтгэлдээ, Оросын 1905-1907 оны хувьсгал 1911 онд монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж тусгаар тогтнолоо сэргээхэд үлэмжхэн нөлөөлснийг түүхт баримтаар нотлон харуулав. ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор Х. Пэрлээ «Манжийн төрөөс монголын талаар явуулсан шинэ засгийн бодлогын харгис шинж чанар» гэсэн илтгэлдээ, уг бодлогын хүчээр хятадчилах харгис мөн чанарыг илчлэхийн хамт, тэр бодлого монголчууд үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө босч тэмцэхэд хүргэсэн. Өнөөгийн Бээжингийн эрх баригчид хятад биш үндэстний цөөнх ард түмнийг хүчээр хятадчилах бодлого явуулж байгаа нь Цин улсын шинэ засгийн бодлоготой чанар адил байна гэж тэмдэглэв.

Профессор С. Д. Дылыков «1911-1912 оны монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үе дэх Өвөр Монголын байдал»